

МОНГОЛ УЛС  
ШАДАР САЙДЫН ТУШААЛ

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын бүс, бүсийн төвийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журамтай холбогдуулан Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын бүсийн төвүүдийн бүтэц, орон тоог баталж, гамшгаас хамгаалах арга хэмжээг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга (бригадын генерал Т.Бадрал)-д даалгасугай.

Гарын үсэг

ОНЦГОЙ БАЙДЛЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН БАЙГУУЛЛАГЫН  
БҮС, БҮСИЙН ТӨВИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журам нь гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг бүсийн хэмжээнд зохион байгуулах, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын бүсийн төв, харъяа Онцгой байдлын газрын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, эрх, үүрэгтэй холбогдох харилцааг зохицуулахад оршино.

**Хоёр. Хамрах хүрээ, зарчим**

2.1. Онцгой байдлын ерөнхий газрын харъяа орон нутаг дахь салбар, нэгжийг баруун, зүүн, хойд, өмнөд, Улаанбаатарын гэсэн 5 бүсэд хуваана.

2.2. Бүсийн төв болон тухайн бүсэд хамаарах аймгуудын Онцгой байдлын газрыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 66 дугаар тогтоолд зааснаар ойлгоно.

2.3. Улаанбаатарын бүсийн үйл ажиллагааг энэ журмаар зохицуулахгүй.

2.4. Бүс нь гамшгаас хамгаалах нэгдсэн болон бүс хооронд дэмжлэг үзүүлэх, харилцан ажиллагааг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах, хүч хэрэгсэл, удирдлага зохион байгуулалт, хяналт, Газруудын гүйцэтгэх үүргийг тодорхойлсон хамтран ажиллах төлөвлөгөөтэй байна.

2.5. Бүсийн төвүүд тухайн бүс нутгийн гамшгаас хамгаалах нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, Онцгой байдлын ерөнхий газрын даргаар батлуулна.

2.6. Бүсийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална.

2.6.1. Нэгдмэл удирдлага, зохион байгуулалттай, шат дараалсан байх

2.6.2. Хамтран ажиллах, харилцан дэмжлэг үзүүлэх, ил тод нээлттэй, шударга байх

2.6.3. Шуурхай, бодит үр дүнд чиглэсэн байх

**Гурав. Удирдлага, зохион байгуулалт**

3.1. Бүсийн төвийн удирдлага нь тухайн бүсийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана.

3.2. Бүсийн төвийн удирдлага нь бүсийн төвийн дарга болон штабын дарга байна.

3.3. Бүсийн төв нь бүсийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий штабтай байна.

3.4. Бүсийн төвүүд шуурхай удирдлага, зарлан мэдээлэх нэгжтэй байх бөгөөд нэгж нь бүсийн хэмжээнд гамшгийн аюулын мэдээ, мэдээллийг хүлээн авах, дамжуулах, зарлан мэдээлэх, сэрэмжлүүлэх, гамшгийн үеийн удирдлагын холбоог зохион байгуулах чиг үүрэгтэй байна.

3.5. Бүсийн төвүүд нь Онцгой байдлын ерөнхий газартай мэдээлэл холбооны нэгдсэн сүлжээгээр холбогдон ажиллана.

3.6. Онцгой байдлын газрууд нь харъяалах нутаг дэвсгэрт тохиолдсон аюулт үзэгдэл, ослын мэдээг Онцгой байдлын ерөнхий газар болон бүсийн төвд шуурхай мэдээлнэ.

3.7. Бүсийн төв нь аюулт үзэгдэл, ослын мэдээллийн санг бүрдүүлэхдээ Онцгой байдлын ерөнхий газрын “Цахим бүртгэл мэдээллийн систем”-ийг ашиглана.

3.8. Бүсийн хэмжээнд зарлан мэдээллийн системийг бүсийн төвөөс удирдах бөгөөд зарлан мэдээлэх системийн тоног төхөөрөмж нь Онцгой байдлын ерөнхий газрын Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвтэй зохицон ажиллах боломжтой байхаар зохион байгуулагдана.

3.9. Бүс нутгийн хил дамнасан гамшгийн нөхцөл байдлын цар хүрээ, шинж байдлаас шалтгаалж шуурхай зохицуулалтын удирдлагыг нэг бүсээс нөгөө бүс рүү шилжүүлэх асуудлыг Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгжийн даргын саналыг үндэслэн Онцгой байдлын ерөнхий газрын дарга шийдвэрлэнэ.

3.10. Бүсийн төв нь бүсийн хэмжээний үйл ажиллагаанд ашиглах хэвлэмэл хуудас, дардас хэрэглэнэ.

3.11. Бүсийн төв нь харъяа Онцгой байдлын газрын дарга нараас бүрдсэн зөвлөлтэй байна. Зөвлөлийн ажиллах журмыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга батална.

3.12. Бүсийн төв нь бүсийн хэмжээнд гамшгаас хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн нэгдсэн арга хэмжээг Онцгой байдлын ерөнхий газарт танилцуулна.

3.13. Бүсийн төвийн үйл ажиллагаатай холбогдох зардлыг Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид зааснаар шийдвэрлэнэ.

3.1.4. Онцгой байдлын газрууд үйл ажиллагаагаа Онцгой байдлын ерөнхий газарт тайлагнана.

## **Дөрөв. Бүсийн төвийн удирдлагын эрх, үүрэг**

4.1. Бүсийн төвийн дарга нь бүс нутгийн хэмжээнд дараах эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллана.

4.1.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах;

4.1.2. Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа, нэгдсэн дадлага сургуулийг зохион байгуулах;

4.1.3. Гамшгаас хамгаалах чадавхийг дээшлүүлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, энэ чиглэлээр санал боловсруулж шийдвэрлүүлэх;

4.1.4. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх төлөвлөлт, дадлага сургалт зохион байгуулах;

4.1.5. Бүсийн аймгуудын орон нутгийн удирдлага, онцгой комисстой гамшгаас хамгаалах асуудлаар шууд харилцах, гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

4.1.6. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан бүс нутгийн үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудыг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах, харилцан ажиллагааг хангах;

4.1.7. Онцгой байдлын газруудын гамшгаас хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, мэдээ, тайлантай танилцах, шалган зааварчлах, зөвлөмж, үүрэг даалгавраар хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

4.1.8. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой тушаал, шийдвэр гаргах, удирдамж, төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх;

4.1.9. Үүссэн гамшгийн нөхцөл байдлын үед бүсийн харъяа Онцгой байдлын газраас хүч хэрэгслийг дайчлан гаргах;

4.1.10. Бүсийн цаг агаар, газар зүйн онцлогт тохируулан Онцгой байдлын газрын албан хаагчдыг дулааны болон хүйтний улирлын хувцсанд шилжүүлэх;

4.1.11. Харъяа Онцгой байдлын газруудын хүний нөөц, санхүү, дотоод үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байх;

4.1.12. Гамшгийн аюулыг шуурхай зарлан мэдээлэх;

4.1.13. Үүссэн гамшгийн нөхцөл байдалтай уялдуулан шаардлагатай тохиолдолд иргэдийн дунд дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах

4.2. Штабын дарга нь бүс нутгийн хэмжээнд дараах эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллана.

4.2.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах;

4.2.2. Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх;

4.2.3. Анги, салбаруудын хүч хэрэгслийн мэдээг нэгтгэж, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах;

4.2.4. Эрэн хайх, аврах, холбоо, зарлан мэдээллийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдалд хяналт тавих;

4.2.5. Гамшгийн нөхцөл байдлын үед Онцгой байдлын газрыг холбогдох дүрэм, журмын дагуу мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

### **Тав. Бүсийн Онцгой байдлын газруудын эрх, үүрэг**

5.1. Онцгой байдлын газрууд нь гамшгаас хамгаалах чиглэлээр бүсийн удирдлага, зохион байгуулалтад орж ажиллахаас гадна орон нутгийн түвшинд хуулиар хүлээсэн эрх, үүргээ бие дааж хэрэгжүүлнэ.

5.2. Улсын болон орон нутгийн нөөцийн бараа, материалын бүрдүүлэлт, хадгалалт, зарцуулалтад хяналт тавих, зохион байгуулах;

5.3. Хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалыг холбогдох шийдвэрийн дагуу хуваарилах, хяналт тавих, олон нийтэд мэдээлэх;

5.4. Онцгой байдлын газрууд нь бүсийн төвийн өмнө дараах үүрэг, чиглэл хүлээнэ:

5.4.1. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангаж, бүсийн гамшгаас хамгаалах нэгдсэн төлөвлөгөөнд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах;

5.4.2. Бүсийн төвийн удирдлага болон бүсийн хэмжээнд Онцгой байдлын газруудыг шаардлагатай үнэн зөв мэдээ, мэдээллээр хангах;

5.4.3. Бүсийн төвийн удирдлагаас гамшгаас хамгаалах чиглэлээр өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах;


5.4.4. Бүсийн хэмжээнд зохион байгуулах гамшгаас хамгаалах нэгдсэн арга хэмжээнд бэлэн байдлаа хангаж оролцох.

### **Зургаа. Бусад**

6.1. Бүсийн төвүүд нь үйл ажиллагааны тайлан мэдээг улирал бүр нэгтгэж Онцгой байдлын ерөнхий газарт ирүүлнэ.

6.2. Бүсүүдийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хагас, бүтэн жилээр Онцгой байдлын ерөнхий газраас үнэлж дүгнэнэ.

# ГАМШГИЙН АЮУЛЫГ ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ БҮДҮҮВЧ



# ГАМШГИЙН ҮЕИЙН ХОЛБОО ЗОХИОН БАЙГУУЛАХ БҮДҮҮВЧ

